



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 330

Улаанбаатар хот

“Нэйшнл лайф даатгал” ХХК-д дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/- ийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээг хувьцаа эзэмшигч “Эф Эс Си Өү” ХХК нь 500,000,000 /таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

№	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь /%/
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1	“Эф Эс Си Өү” ХХК	4,000,000,000	500,000,000	4,500,000,000	100%
	Нийт	4,000,000,000	500,000,000	4,500,000,000	100%

2. Дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн холбогдох баримтыг 2015 оны 8 дугаар сарын 10-ны дотор Хороонд ирүүлэхийг “Нэйшнл лайф даатгал” ХХК /Г.Монголхүү/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бүртгэл зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000934